



ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 110

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, компанийн хөдөлмөрийн дотоод журмын 4.1 дэхь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчим хүчний тухай хууль шинэчлэлтэй холбогдуулан компанийн хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлага, зорилгод нийцсэн үйл ажиллагааг зөв зохион байгуулах, байгууллагын гадаад, дотоод орчинд дүн шинжилгээ хийх, төсөв, зардлыг зөв зохион байгуулах зорилгоор 2017 оны бизнес төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

С.Намчиндорж

Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

Д.Байгалмаа

Эдийн засагч

Гишүүд:

Б.Баатар

Ахлах диспетчер

Ч.Амарсанаа

РХАА-ны ахлах инженер

У.Баатарцогт

ГТТА-ны ахлах инженер

Х.Бямбажав

АЗА-ны ахлах мэргэжилтэн

Д.Нацагдорж

МТХА-ны ахлах инженер

2. Компанийн үйл ажиллагаа, эд засаг, санхүүгийн байдалд дүн шинжилгээ хийж бизнес төлөвлөгөөг боловсруулан захирлын зөвлөлийн хуралд 2016 оны 09 дугаар сарын 15 дотор танилцуулахыг ажлын хэсэг /С.Намчиндорж/-т үүрэг болгосугай.

3. Бизнес төлөвлөгөөний зардал, хөрөнгийн хэмжээнд хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /Б.Баярцэнгэл/-д зөвшөөрсүгэй.

4. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа хүний нөөцийн хэлтэс /С.Намчиндорж/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.ЦОГТБААТАР